

**ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2025-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, бусад хуулиар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлэн, орон нутагт нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, хурлын байгууллагын үйл ажиллагааны уламжлал, шинэчлэлийг хослуулах, Улсын Их Хурал, Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагын ажлыг удирдан чиглүүлэх, сумын эдийн засаг, нийгмийн байдлыг дээшлүүлэн хөгжүүлэх чиглэлийг баримтлан, иргэд сонгогчдийн нийтлэг эрх ашигт нийцүүлэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Хурлын төлөөлөгчийн бие даасан байдлыг хангаж ажиллахыг зорилго болгоно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах стратегийг төлөвлөх, оновчтой бодлого боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулалт хийх, бодлогын хэрэгжилтийн явц байдалд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, нутгийн захиргааны байгууллагыг ерөнхий удирдлагаар хангах, төрийн албаны стандартыг хангуулах үүрэг хүлээнэ.

Стратеги төлөвлөгөөний хууль зүйн үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, төсөл, хөтөлбөр, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг болно.

Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		9
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	4
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	5
Ерөнхий чиг үүрэг-1: Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан бүрэн эрх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1:Хурлын зохион байгуулалт,	Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай асуудал;	Төлөөлөгчид
	Хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;	

хяналт шалгалтын талаар:	Тухайн Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх;	Сумын Засаг дарга, Сумын ЗДТГ, Хороод
	тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх;	
	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;	
	тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;	
	Хуульд заасан үндэслэлээр тухайн шатны Засаг даргыг огцруулах талаар дээд шатны Засаг даргад санал тавих;	
Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагаанд хяналт тавих;		
ҮЧҮ-2: Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар:	Нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;	Сумын Засаг дарга, Сумын ЗДТГ, Татварын хэлтэс, Хороод
	Засаг даргын өргөн мэдүүлснээр сумын төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах;	
	Хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;	
ҮЧҮ-3: Орон нутгийн өмчийн талаар:	Орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх;	Сумын Засаг дарга, Сумын ЗДТГ, Хороод
	Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх;	
ҮЧҮ-4: Хууль, эрх зүйн орчны талаар:	Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, мөрдүүлнэ.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Хурлын ажлын алба, Хороод Сумын ЗДТГ,
	Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;	
	Хуулиар тогтоосон тухайн нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, холбогдох журам батлах;	

ГУРАВ.АЛСЫН ХАРАА

Иргэдийн оролцоонд суурилсан сайн засаглалтай нутгийн өөрөө удирдах байгууллага болно.

ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО

“Оновчтой бодлогоор-Тогтвортой хөгжлийг хангана.”

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Жаргалант сумын ИТХ-ын орчны шинжилгээний СВОТ хүснэгт

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
<p>-Орон нутагт тулгарч байгаа асуудлаа өөрсдөө бие даан шийдэх боломжтой.</p> <p>Хурлын үйл ажиллагаа тасралтгүй, тогтмол зохион байгуулагддаг.</p> <p>Төсөв харьцангуй боломжтой</p> <p>Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ хүртээмжтэй</p> <p>Хурлын төлөөлөгчид болон иргэдэд хүргэх мэдээллийг цахимаар тогтмол хүргэдэг.</p> <p>Төлөөлөгч болон ажлын албаны албан хаагчдыг мэргэшүүлэх чадавхижуулах сургалтыг жилд 2 удаа тогтмол зохион байгуулдаг.</p> <p>Хамт олны эерэг таатай уур амьсгалтай</p>	<p>-Сонгогдсон төлөөлөгчдийн хандлага харилцан адилгүй.</p> <p>-Нутгийн удирдлагаар мэргэшсэн хүний нөөц хомс.</p> <p>-Хурлын хороо, зөвлөлийн ажил тогтмолжоогүй.</p> <p>-Гаргасан шийдвэрт хяналт үнэлгээ хийх тогтолцоо муу.</p> <p>-Бодит судалгаа, тооцоонд суурилсан шийдвэр гаргах асуудал дутмаг.</p> <p>-Хурлын төлөөлөгчид өөрсдөө шийдвэрийн төсөл санаачлан шийдвэрлүүлэхэд хойрго хандсаар байна.</p> <p>-Ажлын албаны албан хаагчдын хүрэлцээ муу, мэргэшсэн боловсон хүчин дутмаг.</p> <p>Байгалийн давагдашгүй хүчин зүй тулгарахад малчид болон иргэдэд төрийн болон тусламжийн үйлчилгээг хүргэхэд албаны машин хуучин тул эвдрэл гэмтэл байнга гардаг</p> <p>Хурлын ирц 100% бүрэлддэггүй</p> <p>Мэдээллийн аюулгүй байдал/Цахим болон цаасан баримт бичгийн хадгалалт хамгаалалт муу, баримт бичиг алга болдог аюултай/</p>
Гадаад орчин	
Боломж	Эрсдэл
<p>-Төсвийн эрх мэдэл нэмэгдсэн.</p> <p>-Иргэдийн НӨУБ-ыг ойлгох хандлага сайжирч байгаа.</p> <p>-Төлөөллийн ардчиллын зарчмыг хослуулан шийдвэр гаргах боломж бүрдэж байгаа.</p> <p>-Мэдээлэл солилцох боломж нэмэгдсэн.</p> <p>-Иргэд, ТББ-ууд шийдвэрийн төсөлд саналаа тусгуулах боломж бүрдсэн.</p>	<p>-УИХ-ын сонгуулийн үр дүнгээс хамаарч аймаг, сумдын ИТХ-ын үйл ажиллагаанд хүндрэл үүсдэг.</p> <p>НӨУБ-ын үйл ажиллагааны талаар иргэд олон нийт харилцан адилгүй ойлголттой НӨУБ-д хандах хандлага бүрэн төлөвшөөгүй.</p> <p>-Сонгогдсон төлөөлөгчдийн асуудалд хандах хандлага харилцан адилгүй.</p>

	<p>-Эдийн засгийн хувьд хараат.</p> <p>-ИТХ, ИНХ харилцан уялдаа, хамтын ажиллагаа сул.</p> <p>-Гаргаж байгаа шийдвэр олон талын эрх ашгийг хамгаалж чадахгүй байгаа.</p> <p>-Бодлогын судалгаанд суурилж шийдвэр гаргаж чадахгүй байна.</p>
--	--

ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд 2021-2024 онд дор дурдсан стратегийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Стратегийн зорилт 1: Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэлийг тодорхойлоход нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, хурлын байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

Стратеги зорилт 2: Сумын ИТХ-ын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгож, түүний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх.

Стратеги зорилт 3: Сумын ИТХ-ын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, эргэх холбоог бий болгох.

Стратеги зорилт 4: Сумын ИТХ-ын Ажлын албыг бэхжүүлж, үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын чанарыг сайжруулах.

Стратеги зорилт 5: ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр өгөөжийг тогтвортой дээшлүүлэх.

ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Стратеги зорилт 1-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1.1. Сумын ИТХ-ын хуралдаан, зөвлөлийн хуралдааны дэг, ИТХ-д мөрдөх журам, дүрмийг боловсруулан мөрдөх;

1.2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жил бүрийн төлөвлөгөө, хөтөлбөрийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох;

1.3.Холбогдох байгууллагуудтай хамтарч эдийн засаг, нийгмийн хөгжлийн цаг үеийн тулгамдсан асуудлаар судалгаа, шинжилгээ хийж санал боловсруулах, батлуулах, биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцох;

1.4.Орон нутгийн төсөв боловсруулах, хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавьж гүйцэтгэлийг батлах;

1.5.Бүс нутгийн болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжтэй хамтран ажиллах гэрээ, хөтөлбөр, бусад баримт бичгийг батлах;

1.6.Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг төлөвлөх, батлах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

1.7.Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох;

1.8.Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг ханган хуралдах;

1.9.Сумын хэмжээнд төлөөллийн чиг үүрийг хэрэгжүүлэх, төлөөлөгч өөрийн сонгогдсон тойрогтоо ажиллах, иргэдтэй уулзах, улирал тутам хийсэн ажлын тайланг танилцуулах, дүгнэлт хийх;

1.10. Хууль тогтоомж, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний харьяа байгууллага, аймгийн ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах үйл ажиллагааг зохион байгуулах;

1.11. Иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;

1.12. ИТХ-ын төлөөлөгчид, Хороодын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог хангах, дэмжлэг үзүүлэх, идэвхжүүлэх, ажлыг нь дүгнэх, урамшуулах;

1.13. ИТХ-ын, төлөөлөгчдийн иргэд сонгогчидтойгоо ажиллах нөхцөлийг бүрдүүлэн “Төлөөлөгч-Иргэд”-ийн хамтын ажиллагааг сайжруулах;

Стратеги зорилт 2-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1. Хурлын байгууллагаас батлагдан гарсан шийдвэрийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх цахим программыг нэвтрүүлэн үйл ажиллагааг тогтмолжуулах;

2.2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгүүлж, дүгнэлт өгөх;

2.3. Сумын ИТХ-аас хийх хяналт шалгалтын ажилд төрийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

2.4.Төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах арга механизмыг боловсронгуй болгож, төгөлдөржүүлэх;

2.5. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хороодын хурлаар хэлэлцүүлэх асуудлын судалгааг хийж, шаардлага хангасан эсэхэд дүгнэлт хийж, нийтийн эрх ашигт нийцсэн оновчтой шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх, биелэлтийг хангахад хяналт тавьж үр дүнг тооцох;

2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд иргэдийн оролцоог хангаж, хянан шалгах;

2.7 Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах;

2.8. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хянан шалгах;

2.9. Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт шалгалтыг сайжруулж, иргэдэд мэдээлэх.

Стратеги зорилт 3-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1. Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлж, иргэдийн оролцоог дэмжсэн цахим орчин бүрдүүлж, байгууллагын вэб сайттай болж, олон нийтэд нээлттэй, ил тод цахим хурал болох;

3.2. Сумын ИТХ-ын хуралдаан болон Хороодын хуралдааны явцын мэдээллийн шуурхай, чанартай байдлыг хангах системийг нэвтрүүлэх;

3.3. Сумын ИТХ-ын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, шаардлагад нийцсэн мэдээ, мэдээллийн булан байгуулах;

3.4.Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, төлөөлөгчдийн статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

3.5. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

3.6. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлыг иргэдэд мэдээллийн ил тод нээлттэй, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд иргэдийн санал, хүсэлтийг сонсох, тусгах, дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх замаар иргэдийн оролцоог хангах.

Стратеги зорилт 4-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1. Ажлын албаны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох;

4.2. Ажлын алба нь төрийн албаны болон бусад холбогдох дүрэм, журам, зааврыг баталж мөрдөн ажиллах;

4.3. Удирдлагын манлайлах чадварыг сайжруулах, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, цалин хөлс, урамшууллын тогтолцоо, нийгмийн баталгааг сайжруулах замаар хүний нөөцийн чадавхийг дээшлүүлнэ;

4.4. Албан хаагчдын ажил, үйлчилгээг шуурхай, цаг хэмнэсэн шаардлагатай программ хангамж, цахим үйлчилгээг нэвтрүүлэх;

4.5. Сумын ИТХ-ын төлөөлөгч, Ажлын албаны албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн дотоод болон гадаад улс орнуудын туршлагаас суралцаж сайн туршлагыг нэвтрүүлэх, мэргэшүүлэх, хамтран ажиллах;

4.6. Хурлын төлөөлөгч нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтад хамруулах, чадавхжуулах, гарын авлага, мэдээллээр хангах;

4.7. Сумын ИТХ-аас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдлийн удирдлагаар хангах;

4.8. Сумын ИТХ-ын ажлын албаны ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, бүтэц орон тоог нэмэгдүүлэх;

4.9. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

4.10. Сумын ИТХ-ын ажлын албаны ажилтанг сургалтанд хамруулах, туршлага солилцох, мэргэшүүлэх, давтан сургах арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;

4.11. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэх;

4.12. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, дүнг тайлагнах;

4.13. Авлигатай тэмцэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дүнг Авлигатай тэмцэх газарт тайлагнах;

4.14. Шашин сүм, хийдийн үйл ажиллагаатай холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.15. Иргэний танхимын үйл ажиллагааг өргөжүүлэн, үйлчлүүлэгчдэд мэдээ, мэдээлэл авах нөхцөл боломжийн бүрдүүлэх, багууд болон сумын иргэний танхимын үйл ажиллагаатай холбогдолтой мэдээ тайланг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх.

Стратеги зорилт 5-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1. Сумын иргэдийн Төлөөлөгч, багийн ИНХ-ын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг бүх талын туслалцаа үзүүлэх;

5.2. Сумын ИТХ-ын төлөөлөгчид болон багуудын ИНХ-ын дарга, зөвлөлийн гишүүдийг сургалтанд хамруулах, туршлага солилцох боломжоор хангах;

5.3. Багийн ИНХ-ын үйл ажиллагааны ажлын үр дүнг үнэлж, дүгнэн урамшуулах;

5.4. Иргэд олон нийттэй харилцах, хурал, сургалт сурталчилгаа явуулахад дэмжлэг үзүүлэх, ажиллах нөхцөл боломжоор хангаж дэмжлэг туслалцаа үзүүлэх.

НАЙМ. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.

- 1.1. Энэхүү төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.
- 1.2. Стратеги төлөвлөгөөний зорилтыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгаж хэрэгжүүлнэ.
- 1.3. Сумын иргэдийн төлөөлөгчдийн Хурлын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцон тайлагнах үүргийг сумын ИТХ-ын ажлын алба хариуцна.
- 1.4. Төлөвлөгөөний биелэлт, тайлангийн мөрөөр хэрэгжээгүй буюу дутуу биелэлттэй ажлын талаар эрчимжүүлэх арга хэмжээ авна.
- 1.5. Стратегийг хэрэгжүүлэх санхүүгийн болон хүний нөөцийг оновчтой тооцож жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээг зохион байгуулна.

---oOo---